Жоншны нэр болон ангилалыг сурвалж, тайлбарын хүрээнд судалж тодруулсан нь

О.Отгончимэг[1], С.Жаргалсайхан[2], С.Сээсрэгдорж[1]

[1]АШУҮИС, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль
[2]АШУҮИС, Дорноговь Анагаах Ухааны Сургууль
Цахим хаяг: orshih.otgonchimeg@gmail.com, Утас: 89021232

Түлхүүр үг:
Чулууны хаан
Ясны тэжээл
Уламжлалт
Сурвалж
Ангилал

Товч утга:
Үндэслэл: Уламжлалт анагаах ухааны сурвалж, тайлбаруудад жоншны нэршил нь олон янзын ёгт утгатай байгаа нь эндүүрэхэд хүргэхээр байдаг. Жоншны ангилалтай уялдуулан таних аргыг нарийвчлан тогтоосноор эмийн эрдэм, чадлыг бүрэн гаргах, эмчилгээний үр дүнг сайжруулах ач холбогдолтой юм. Иймээс сурвалж, тайлбаруудын хүрээнд жоншны нэршлийн ёгт далд утга, ангилалыг харьцуулан судлах зорилгын хүрээнд сурвалж, 5-н томоохон тайлбаруудыг эх хэрэглэгдэхүүн болгож “Эх бичиг, сурвалж судлалын харьцуулах арга”, “Анализ-синтезийн арга” “Герменевитик арга” “Магадлан жагсаах арга”-аар судалгааг хийж гүйцэтгэлээ. **Үр дүн:** Эмийн чадал үйлдлийн талаас нэрийдсэн чулууны тунгалаг, чулууны шим, ясны тэжээл хэмээх ёгт нэршил нь эх хэрэглэгдэхүүн болгож байгаа бүтээлүүдэд ижил төстэй байна. Дээрх домогтой холбоотой “Шөнийн гэрэлт”, “Сарны хүү”, “Тэнгэрийн хөвүүний дусал”, “Сансрын махбодь”, “Чулууны өөх”, “Сансрын цагаан бодь сэтгэл” хэмээн нэрлэдэг. Чулуун жүдлэнгийн гол эм болох тул чулуун дажид, өөхөн дарьяаган гэж нэрлэсэн байна. Язгуурын ангилалд жоншийг тус бүр дотор нь дээд, эрхэм, дунд, адаг хэмээх дөрвөн ялгалд хуваасан байдаг. Жоншны таван язгуурын ангилал болон дөрвөн зэрэглэлийн ялгалтай нийт 20 дэд ангилал болж өргөжсөн байна. Түүнчлэн жоншны таван язгуур дөрвөн ялгал нь цаашид дан өнгөний ангилалд хуваагдан дэлгэрч 100 зүйл болж нарийвчлагдан ангилаж үзжээ. Мөн холилдсон 25 өнгө тус бүрийг таван язгуур, дөрвөн зэрэглэл ангилалтай харшалдуулан нийт 500 төрлийн жонш болох тухай уламжлалт сурвалж, тайлбаруудад нарийвчлан ангилж уламжлагдсан байна. Эдгэрийн ангилалын хоорондоо холилдсон хэмжээний их, багаас шалтгаалан тоолшгүй олон болно хэмээн сурвалж, тайлбаруудад тэмдэглэсэн байна. **Дүгнэлт:** 1. Жоншийг гадаад байдалтай холбож 18-н зүйлээр ангилсаны онцлог нь жоншны үүсэл гарлын домогтой болон түүний өргөн хүрээний үйлдэл үзүүлдэгтэй холбоотой байна. 2. Сурвалж, тайлбаруудад жоншыг тодорхой 500 төрөлд ангилаад өнгөний холилдсон байдлыг хэмжээнээс хамаарч илүү олон төрөлд ангилж болохыг тэмдэглэжээ.

Үндэслэл: Уламжлалт анагаах ухааны эм найрлагад жоншийг өргөн хүрээтэй хэрэглэж ирсэн бөгөөд архаг өвчний шалтгаан эс шингэх, бор, шар бадган, хорын өвчнүүд болон хүйтэн, халуун өвчин бүгдэд тустай хэмээн анагаах ухааны сурвалж, тайлбаруудад бичсэн байдаг. Уламжлалт анагаах ухааны сурвалж бичгүүдэд эмт бодис тус бүрийн гарал үүслийн домогзүй, ангилал таних арга, эмийн чадал үйлдэл, тэргүүтэнтэй холбогдсон байдгаас жоншны нэршил нь олон янзын далд ёгт утгатай байх бөгөөд эндүүрэх тохиолдол гардаг. Мөн ангилал болон таних аргыг нарийвчлан мэдсэнээр эмийн эрдэм чадлыг бүрэн гаргах, эмчилгээний үр дүнг сайжруулах ач холбогдолтой юм. Иймээс нэршил болон ангилалыг судлан тогтоох нь

хэрэглэгээний ач холбогдолтой байна[3-5].

Зорилго: Уламжлалт анагаах ухааны эх сурвалж, тайлбаруудын хүрээнд жоншны нэршил болон ангилалыг судлан тогтоох.

Зорилт:

1. Жоншны нэршлийн олон талт байдлыг эх сурвалж, тайлбар, бүтээлүүдээс тодруулж онцлогийг тогтоох
2. Жоншны ангилал болон таних аргыг эх сурвалж, тайлбар бүтээлүүдээс тодруулах

Материал арга зүй:

Үндсэн эх хэрэглэгдэхүүн:

1. Их Ютог Ёндонгомбо "Рашааны шим найман гишүүн нууц увдисын үндэс" Бээжин 2002. Уг бүтээл нь 26см*18см хэмжээтэй, 156 бүлэг, 17 мөр, 669 хуудастай, Төвд хэлээр. Хуудас 3

Харьцуулсан эх хэрэглэгдэхүүн:

2. Дэсрид Санжаажамц "Хөх биндэръяа" 18-р Боть. Бээжин: 2008. Тэргүүн дэвтэр нь 19см*14см хэмжээтэй, 78 бүлэг, 22 мөр, 733 хуудастай. Төвд хэлээр. XVII зуунд бичигдсэн. Хуудас 28
3. Дэмүр Данзанпунцаг Эмийн хиргүй болор эрхи, 15-р Боть. Бээжин 2005, 850мм*1168мм хэмжээтэй, 24 мөр 472 хуудастай. Төвд хэл дээр XVII зуунд бичигдсэн. Хуудас 112-114, 116-117
4. Ютог Ёндонгомбо Буман өвсөн эмийн сан хөмрөг. 40-р Боть. Бээжин 2006, 850мм*1168мм хэмжээтэй, 24 мөр, 407 хуудастай, Төвд хэл дээр XVII зуунд бичигдсэн. Хуудас 280-282, 284-286
5. Дармамаарамба Лувсанчойдог Алтан хадмал гайхамшигт сан хөмрөг. 35-р Боть. Бээжин 2006, Төвд хэл дээр бичигдсэн. XVII зуунд бичигдсэн. хуудас 8-12
6. Жанбапунцог Түнбэдимэдшилжимэлон. Бээжин 1995, 787мм*1092мм, XX зуунд бичигдсэн. Хуудас 132-136

Дээрх сурвалж тайлбаруудыг "Эх бичиг, сурвалж судлалын харьцуулах арга"-аар тодруулж, харьцуулан, "Герменевтик арга"-аар Төвөд эхээс Монгол хэлэнд орчуулан "Магадлан жагсаах арга"-аар ангилан, "Анализ синтезийн арга"-аар шинжлэл хийж дүгнэлт гаргалаа.[8,9,10]

Үр дүн:

Жоншны үүслийн домог: 15-р зууны үеийн Төвдийн эрдэмтэн Тонвадондангийн "Малаягийн бэрхийн тайлбар" бүтээлд жонш чулууны үүсэл гаралтай холбоотой нэгэн домгийг өгүүлэхдээ эрт галавын цагт "Чандмань" нэрт тэнгэрийн хөвүүн далайн хөвөөгөөр зугаацаж явахдаа лус найман аймгийн охинтой учирч ойртсоноос тэдний цагаан, улаан дусал хадан дээр дуссанаас барагшин хийгээд жонш үүссэн тухай дурдсан байдаг. "Тэнгэрийн хөвүүний дусал" хадан дээр дуссанаас өөх мэт цагаан чулуу тогтсон нь жонш болсон хэмээсэн энэхүү эртний Энэтхэгийн Ведийн домогтой холбоо нэршлийн зүйлүүд хожмын эмийн сурвалж бичгүүдэд уламжлан гарах болсон байна.[3,4,5]

Нэрийн тайлбар: Жонш гэдэг нь Жон-архаг, Ши-амирлуулагч "Архагийг амарлиулагч" гэсэн утгатай. Учир нь архаг өвчний шалтгаан эс шингэх тэргүүтэн дөрвөн аймаг архаг өвчнийн зүйлүүдийг амарлиулдаг тул жонш хэмээн нэрлэсэн гэдэг. Мөн жоншийг "Ганцаар чадагч" хэмээн нэрийддэг нь халуун, хүйтэн өвчин бүгдэд рашаан лугаа адил анагаадаг учраас ийнхүү нэрлэжээ.[2,3,4,5] Мөн харагдах байдал, үйлдэлтэй нь холбож язгуурын таван жоншны ангилалыг зохиосон байдаг. Санскритаар "Шилодага" хэмээдэг.[3,4,5]

Ёгт нэршил: Эмийн чадал үйлдлийн талаас нэрийдсэн "Чулууны тунгалаг", "Чулууны шим", "Ясны тэжээл" хэмээх ёгт нэршил нь эх хэрэглэгдэхүүн болгож байгаа бүтээлүүдэд ижил төстэй байна.[2-6]

Дээрх домогтой холбоотой "Шөнийн гэрэлт", "Сарны хүү", "Тэнгэрийн хөвүүний дусал", "Сансрын махбодь", "Чулууны өөх", "Сансрын цагаан бодь сэтгэл" хэмээн нэрлэдэг. Жонш чулуун жүдлэнгийн гол эмийн түүхий эд болох учир "Чулуун дажид", "Өөхөн дарьяаган" гэж нэрлэсэн байна.[3-6]

Язгуурын ангилал: Сурвалж бичиг тайлбаруудад дурдсанаар жоншийг үндсэн 5 язгуурт (эр, эм, манин, хүү, охин) ангилж язгуур тус бүрийг дотор нь чанар, хэлбэр дүрс болон өнгөөр нь нарийвчлан ангилсаар иржээ. "Анагаах ухааны дөрвөн үндэс", "Хөх биндэръяа" эх сурвалжуудад зөвхөн жоншны язгуурын ангилал товч дурдагдсан бол "Эмийн хиргүй болор эрхи", "Буман өвсөн эмийн сан хөмрөг", "Түнбэ" зэрэг сурвалжуудад жоншны язгуурын таван ангилал тус бүрийн дотор нь дээд, эрхэм, дунд, адаг гэсэн дөрвөн ялгалд хуваан ялгал тус бүрт харгалзах онцлог, таних аргыг тайлбарласан байлаа. Мөн жоншны таван өнгийг дангаар нь болон холилдсон тохиолдлуудыг дурдаж өвчтөнд өгөх ёсыг дэлгэрэнгүй тайлбарлан бичжээ. Жоншны ангилалыг доорх Хүснэгт 1-д дэлгэрэнгүй харуулав.

Язгуурын ангилал тус бүр дотроо дээд, эрхэм, дунд, адаг хэмээх дөрвөн ялгалд хуваагдана. Иймээс таван язгуур дөрвөн ялгал нь нийт 20 дэд ангилалд задарна.[3-5]

Хүснэгт 1: Жоншны ангилал

ЭР ЖОНШНЫ ЯЗГУУР	
Дээд	Дээд нь дөрвөлжин жамц давстай адилхан. Яаж ч хагарсан дөрвөлжин. Тал нь тунгалаг, нэвт харагдна.
Эрхэм	Эрхэм нь адууны шүдийг хугалсантай адил зураснууд нь ширүүн гэрэл ихтэй, цагаан хатуу байна.
Дунд	Дунд нь лууванг хэрчисэнтэй адилхан. зурааснууд нь зөөлөн, өнгө нь цагаан булингартсан.
Адаг	Адаг нь өөхөн цагаан чулуутай адилхан гэрэл өчүүхэн, хатуу, цайвар хөх, хорхой идсэн өөхөн чулуутай адилхан.
ЭМ ЖОНШНЫ ЯЗГУУР	
Дээд	Дээд нь ман гавартай адилхан, цагаан зөөлөн, хөрөлсөн цастай адилхан.
Эрхэм	Эрхэм нь шилэн зүүг зэрэгцүүлсэнтэй адилхан нарийн шигүү, урт зураастай, хавтгай шилтэй адилхан тунгалаг. Ширхэгээр нь салгаж болно. хэмхэлвэл нарийхан ширхэгтэй болно.
Дунд	Дунд нь мөсөн унжлагатай адилхан. Ширхэг нь зөөлөн, булингартсан, дээрээсээ мөс хөлдөөд доошоо унжсантай адилхан.
Адаг	Адаг нь шилний нунтагтай адилхан, гэрэлтдэг, богинохон нарийхан ширхэгтэй.
МАНИН ЖОНШНЫ ЯЗГУУР	
Дээд	Дээд нь шөрмөсөн чулуутай адилхан. Зөөлөн урт ширхэгтэй, багцалсан шөрмөстэй адилхан.
Эрхэм	Эрхэм нь мөс овоорсонтой адилхан.
Дунд	Дунд үнээний хөхтэй адилхан дээрээсээ доошоо дусал тогтсонтой адил.
Адаг	Адаг шороо ч биш, чулуу ч биш, зөөлөн хар бараан сэвсгэр, хөнгөн, хэмхэлхэд амархан бусад бодисын элдэв хольц орсон байдаг.
ХӨВҮҮН ЖОНШНЫ ЯЗГУУР	
Дээд	Дээд нь сайр тогтсонтой адилхан. Нимгэн болоод гөвдрүүтсэн, сайртсан арьстай адилхан.
Эрхэм	Эрхэм нь сүүний өрөмтэй адилхан, зөөлөн, будаг тогтсон, хөвсгөр зөөлөн
Дунд	Дунд нь эсгийний өөдөстэй адилхан, цагаан нимгэн ээдмэгтсэн хавтгай тогтоцтой нарийн ширхэгтэй.
Адаг	Адаг эрэг, нураа тогтсон адил, тоосготой адилхан цагаан сэвсгэр давхарласан тогтоцтой.
ОХИН ЖОНШНЫ ЯЗГУУР	
Дээд	Дээд нь цагаан гахайн дэл адил, нарийн, нягт, цагаан зөөлөн, зурааснууд нь нарийн зөөлөн элдэг дэлийг боосонтой адилхан.
Эрхэм	Эрхэм нь хөлдүү шилмүүсний хэсэг адил, ирүүн болоод эвдэрсэн мэт ширхэгтэй. ширхэг нь урт, алх нүдүүрээр эвдэхэд хялбар.
Дунд	Дунд муу гантиг чулуутай адилхан, зөөлөн бараан, зураас нь нягт, зөөлөн элдэг.
Адаг	Адаг тасын баасыг номхтгосонтой адилхан, сул, барцилдсан биш нунтгалсан ээзгийтэй адил.


Жоншны өнгөний ангилал: Сурвалж тайлбаруудад жоншийг дээр дурдсан язгуурын ангилалаас гадна 5 өнгөд хуваан авч үздэг. Үүнд.

1. Цагаан: Сааран гэрэлтэх, ширхэг нь бүдүүн уртлаг, ихэвчилэн зургаан талтай хатуу чийрэг.
2. Улаан: Шунхны өнгөт хэмээх нь, ширхэг нь урт зэс зүү зэргэцүүлсэнтэй адилхан. Ширхэг нь улаан бор гэрэлтсэн янз бүрийн байдалай байдаг.
3. Шар: Загасны цөст хэмээх нь бүдүүн ширхэгтэй, уртлаг, хатуу чийрэг, шар тунгалаг байдаг.
4. Хөх: Хөх цацагт хэмээх магад бус хэлбэртэй тунгалаг, хатуу чийрэг, цайвар хөх өнгөтэй.
5. Хөх улаан: Тагтааны хүзүү хэмээх чулууны бүтэц нь дээрхитэй адилхан хэмээн дурдсан байдаг.

Эдгээр таван өнгийн жонш нь дангаараа эсвэл холилдсон хэлбэртэй байдгийг сурвалж бичгүүдэд тэмдэглэжээ. Холилдсон өнгийн жоншийн тоог тооцож үзвэл хоёр өнгө холилдсон 10, гурван өнгө холилдсон 9, дөрвөн өнгө холилдсон 5, таван өнгө холилдсон 1 нийт холимог 25 өнгө болдгийг заасан байдаг.[3-5]

Хэлцэмж: Жоншийг хэлбэр, дүрсээр нь ялган ангилахдаа байгалийн аливаа зүйлийн тогтоц, бүтэцтэй харьцуулан адууны шүд шиг, хөрөлсөн цас шиг, усны дусал адил, өөхөн чулуу, шөрөмсөн чулуу мэт хэмээн өвөрмөц байдлаар илэрхийлсэн нь сонирхолтой шууд ойлгогдохоор байна.[3-6]

"Эмийн хиргүй болор эрхи" номонд эр жоншны талаар дурдахдаа "Дээд нь дөрвөлжин жамц давстай адилхан. Яаж ч хагарсан дөрвөлжин, тунгалаг хэмээн дурдсан байх бөгөөд энэ дүрслэл нь өмнөх судлаачдын бүтээлд хэвлэгдсэн эр жонштой (Зураг 1) харьцуулахад тохирч байгаа төдигүй бичил бүтцийн шинжилгээгээр ч дөрвөлжин мөн чанараа хадаглаж байгаа нь батлагддаг.[3-6]



Зураг 1. а- Жоншны харагдах үлэмж байдал, б-бичил байдал (микроскопи)

Жоншийг язгуур, өнгөөр нь сайтар ялган таньж өвчтний нас, хүйс өвчний онцлогт тохируулан эмийн найрлагад хэрэглэхээр тусгайлан заасан байдаг нь тус судалгааны ач холбогдол оршиж байна. Энэ талаар сурвалж, тайлбаруудад бичгүүдэд тодорхой заасан. Тухайлбал: “Чулууны үндэс” жоншны сударт сайн, муугийн ялгааг үзэж морины шүдийг хугалсан адил, хатуу, хүнд, өөх адил нь цус шарыг дарж, хурмал өвчнийг арилгах ба дийлэхэд бэрх тул идэр залуу настан бээр шүтмой.

Цагаан гантиг хэмээх цайвар сэвсгэр уртлаг зөөлөн эелдэг, халуун эмт устай газар гардаг нь шимийг авахад сайн бөгөөд бадган, цайвар бор шар, толгой хагарсан шарханд рашаан мөн. Энэ хоёр нь эр рашааны зүйл мөн.

Бор үнээний хөх ади нь, асга хадны завсраас гардаг бодит рашаан лугаа адил өвчин бүгдэд дээд хэмээн номлосон. Асга хадны завсруудад шар болоод хагтаж тогтсон шар замаг адил. Шим авах, машид тачаахуй хүчжүүлэх бөөрний өвчинд рашаан адил. Энэ хоёр жонш нь эмийн төрөл бөгөөд рашааны зүйл болой[3,4,5].

Цагаан, улаан, шар болоод уртлаг эелдэг, эр эм хоёул шүтэн үйлдвээс рашаан адил чадалтай болно. Нэр нь манин, өөх мэт бөгөөд шим авхуулахын дээд юм. Эрд эм, эмэгтэйд эр жонш дээд хэмээн сайшаагдсан. Манин жонш сэрүүн бүлээн тэгш, эр, эм хоёул шүтвээс дээд, эр жонш хүрэлцэхүйн бүлээн, эм жонш сэрүүн, манин жонш тэгш зөөлөн, эр жонш нь эмд, эм жонш нь эрд, манин жонш нь хоёуланд нь, халуун дээдэд хөвүүн жонш, охин жонш нь хүйтнийг амирлуулна.

Дээд, эрхэм, дунд, адгаар өвчний хүчийг арилгах ба өвчний хүчинд тааруулна. Товчилвоос өвчтэй, өвчингүйд түүнтэй адил ерөндөг үгүй хэмээн зааж тодорхойлсон байдаг.[3,4,5,6]

"Эмийн хиргүй болор эрхи" сударт цагаан нь бадган, шар нь шард, улаан жоншийг цусны өвчинд, хөх жоншийг хийн өвчинд, тагтааны хүзүү мэтийг хурмалд сайн учир ялгалын хувийг сэтгэлдээ магадлан үйлдээд эм найруулбаас эмчийн эгнээнд багтна. хэмээн заажээ.[3,4,5] Уламжлалт анагаах ухааны сурвалж, тайлбаруудад жоншийг нас, хүйс, өвчний дан болон хавсарсан, хурсан байдалтай холбон эрдэм, чадлыг тодорхой өгүүлж найруулахыг заасан байгаа нь жоншны нэршил, ангилалыг тодорхой таньж мэдэхийн мөн чанар болдог.

Дүгнэлт:

1. Жоншийг гадаад байдалтай холбож 18-н зүйлээр ангилсаны онцлог нь жоншны үүсэл гарлын домогтой болон түүний өргөн хүрээний үйлдэл үзүүлдэгтэй холбоотой байна.
2. Сурвалж, тайлбаруудад жоншыг тодорхой 500 төрөлд ангилаад өнгөний холилдсон байдлыг хэмжээнээс хамаарч илүү олон төрөлд ангилж болохыг тэмдэглэжээ.

Талархал: Энэхүү судалгааны ажлыг хийх нөхцөл бололцоо олгосон Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургуулийн хамт олон, удирдагч С.Сээсрэгдорж багшдаа гүн талархал илэрхийлэе.

Ном зүй:

1. *Ютог Ёндонгомбо “Рашааны шим найман гишүүн нууц увдисын үндэс” Бээжин 2002. Төвд хэл дээр. х.3*
2. *Дэсрид Санжаажамц “Хөх биндэръяа” 18-р Боть. Бээжин: 2008. Тэргүүн дэвтэр. Төвд хэлээр. XVII зуунд бичигдсэн. х.28*
3. *Дэмүр Данзанпунцаг Эмийн хиргүй болор эрхи, 15-р Боть. Бээжин 2005, төвд хэл дээр XVII зуунд бичигдсэн. х.112-117*
4. *Ютог Ёндонгомбо Буман өвсөн эмийн сан хөмрөг. 40-р Боть. Бээжин 2006, төвд хэл дээр XVII зуунд бичигдсэн. х.280-287*
5. *Жанбапунцог Түнбэдимэдшилжимэлон. Бээжин 1995, XX зуунд бичигдсэн. х.132-13*
6. *Дармамаарамба Лувсанчойдог Алтан хадмал гайхамшигт сан хөмрөг.*

35-р Боть. Бээжин 2006, Төвд хэл дээр бичигдсэн. XVII зуунд бичигдсэн. х8-12

7. *Доржбат С, Номхотгосон жоншны бүтцийн судалгаа. АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл 2013. х.14*
8. *Сувд Н, Машбадрах Б, Дэмбэрэлсүрэн Ж, Эрүүл мэндийн судалгааны арга зүй 2001. х. 65*
9. *Баатартогтох Ц, Нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй Улаанбаатар 2010. х. 61*
10. *Зевелев А. И. Историографическое исследование: методологические аспекты. Москва: 1987. х. 40*
11. *Чулуунбаатар Г. Шинжлэх ухаан танин мэдэхүйн логик, судалгааны арга зүй. УБ. 2001. х.115, 122*
12. *Лодой Г.философи ба шинжлэх ухааны арга зүй. УБ. 2002. х. 32, 36*

Comparative study of name and classification of calcite from sources of traditional Mongolian medicine

Otgonchimeg O[1], Jargalsaikhan S[2], Seesregdorj S[1]

[1]MNUMS-MSU-Institute of Traditional Medicine
[2]MNUMS-Medical School of Dornogovi
Email: orshih.otgonchimeg@gmail.com, Tel: 89021232

Introduction: Calcite has been widely used by content of medicine in Traditional Mongolian Medicine. In Traditional Medical sources and interpretations, name of calcite has many hidden meaning that can be misleading. Therefore, comparative study of name and classification of calcite in sources of Traditional Medicine is significant.
Methods: Five sources dictionaries written by Tibetan sages from the 6th century to the first half of the 18th century were compiled in order to compare the names of calcite minerals. The research was conducted using the "Materials and Sources Research Comparison Method", "Accreditation list Method", and "Summary Methodology" as the source materials.
Results: There are three names that is "transparent stone", "rock extract" and "bone supplement" are similar to sources. Also calcite is divided by five main origin and colors. Each classification has four type subclasses that is "premium", "standard", "middle" and "worst". Therefore, total sub classification number of calcite are 500.
Conclusion:

1. Eighteen types of Calcite are classified by their exterior. Each of their names are related to historical story and medical reaction.
2. According to sages there are more over five hundred subclasses of calcite.

Key word: traditional Mongolian medicine, calcite minerals, classification